

## [ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ]

**“ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, УРВАЛЖ БОДИС” ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/  
гэрээний нэр, дугаар:

**ЭСҮТ/201901007**

.....

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

#### Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааг бөглөх санамж

Захиалагчийн шаардлагад нийцсэн тендер бэлтгэхтэй холбоотойгоор тендерт оролцогчдод шаардагдах бүрэн мэдээллийг энэ бүлэгт тусгана. Түүнчлэн тендер хүлээн авах, нээх, үнэлэх, “хамгийн сайн” тендерийг шалгаруулах болон гэрээ байгуулах эрх олгох үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг багтаана. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ захиалагч ТОӨЗ-г чанд мөрдөнө.

Нийлүүлэгчийн гэрээний үүрэг, гэрээний төлбөр, талуудын эрх, үүрэг, хүлээх эрсдэлтэй холбогдсон нөхцөлийг энэ бүлэгт бус харин 6 дугаар бүлэг (гэрээний ерөнхий нөхцөл) болон 7 дугаар бүлэг (гэрээний тусгай нөхцөл)- д тус тус заана.

Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа нь тендерийн баримт бичгийн бүрэлдэхүүн болох ба харин гэрээний хэсэг болохгүй.

# ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

## ГАРЧИГ

### A. Ерөнхий зүйл

1. Тендерийн цар хүрээ
2. Санхүүжилтийн эх үүсвэр
3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл
4. Эрх бүхий тендерт оролцогч
5. Эрх бүхий бараа
6. Түншлэл

### B. Тендерийн баримт бичиг

7. Тендерийн баримт бичгийн агуулга
8. Тендерийн баримт бичгийг тодруулах
9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

### V. Тендер бэлтгэх

10. Тендер шалгаруулалтад оролцох зардал
11. Тендерийн хэл
12. Тендерийн иж бүрдэл
13. Тендерийн маягт болон үнийн хуваарь
14. Хувилбарт тендер
15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт
16. Тендерийн валют
17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт
18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт
19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт
20. Тендер хүчинтэй байх хугацаа
21. Тендерийн баталгаа
22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах

### Г. Тендер ирүүлэх

23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх
24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
25. Хугацаа хоцорсон тендер
26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх
27. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах

### Д. Тендерийг нээх, үнэлэх

28. Тендерийг нээх
29. Нууцлал
30. Тендерийн тодруулга
31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцэх эсэхийг тогтоох
32. Алдааг залруулах
33. Нэг валютэд хөрвүүлэх
34. Дотоодын тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцох
35. Тендерийг үнэлэх, харьцуулах
36. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах
37. Аливаа тендерийг сонгох, эсвэл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх

### E. Гэрээ байгуулах эрх олгох

38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур
39. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх
41. Гэрээнд гарын үсэг зурах
42. Гүйцэтгэлийн баталгаа

# ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1. Тендерийн цар хүрээ**
  - 1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт/ТШӨХ/-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.
  - 1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.
  - 1.3. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.
  - 1.4. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.
- 2. Санхүүжилт-ийн эх үүсвэр**
  - 2.1. Захиалагч дээр дурдсан эм, эмнэлгийн хэрэгслийг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 3. Залилан мэхлэх болон авилгын үйлдэл**
  - 3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцожгэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.
  - 3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөний хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
- 4. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 4.1. Тендерийн урилга нь сонирхосон этгээд бүрт нээлттэй. хуулийн 9 дүгээр 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүрт нэгэн талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
  - 4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй)ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:
    - 4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дамжуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;
    - 4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;
    - 4.2.3. Төрийн өмчтэй болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;
    - 4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд

оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

- 4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 4.2.6. Иlt худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;
- 4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлан сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)

- 4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.

- 5. Эрх бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл**
- 5.1. Гэрээгээр нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТОӨЗ-ны 1.1-д дурдсан барааг худалдан авснаар төлнө.

- 5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан эм, эмнэлгийн хэрэгслийн гарал үүсэл гэдэгт тухайн эм, эмнэлгийн хэрэгслийг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ эм, эмнэлгийн хэрэгсэл гаргаж ирэхийг хэлнэ.

- 6. Түншлэл**
- 6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл” гэх, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер ирүүлэх тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:

- (a) түншлэлийн бүх гишүүдийн хувьд тендер хүчин төгөлдөр байхаар тендерт гарын үсэг зурсан байх;
- (b) ТОӨЗ-ны 1.1-д заасан эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх

хариуцлагыг тодорхойлж хамтран ажиллах гэрээнд тусгасан байх;

- (в) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлэх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;
- (г) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөр тооцоог зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй харилцаж, гүйцэтгэхийг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;
- (д) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.

## B. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

### 7. Тендерийн баримт бичгийн агуулга

7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:

#### I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа  
Бүлэг 2. Тендерийн өгөгдлийн хүснэгт  
Бүлэг 3 Тендерийн үнэлгээнд мөрдөх шалгуур үзүүлэлтүүд  
Бүлэг 4. Тендер шалгаруулалтын маягт
- Тендерийн маягт
  - Унийн хуваарь
  - Тендерийн баталгааны маягт
  - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

#### II ХЭСЭГ

Бүлэг 5. Нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

#### III ХЭСЭГ

- Бүлэг 6. Гэрээний ерөнхий нөхцөл  
Бүлэг 7. Гэрээний тусгай нөхцөл  
Бүлэг 8. Гэрээний маягт
- Гэрээний маягт
  - Гүйцэтгэлийн баталгааны маягт
  - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

- 7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

### 8. Тендерийн баримт бичгийг тодруулах

- 8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар

ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

- 8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэхүү ТОӨЗ-ны 9 дүгээр зүйл, 20.2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.
9. **Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах**
- 9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.2. Ийнхүү хийсэн аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг захиалагчаас тендерийн баримт бичиг шууд худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## B. ТЕНДЕР БЭЛТГЭХ

10. **Тендер шалгаруулалтад оролцох зардал**
- 10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
11. **Тендерийн хэл**
- 11.1. Тендер, түүнчлэн тендертгэй холбоотойгоор захиалагч тендерт оролцгчийн хооронд харилцаж буй албан бичиг, захиалагчид бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвэл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.
- 11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТОӨЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.
12. **Тендерийн иж бүрдэл**
- 12.1. Тендерт оролцгчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;
- (б) захиалагч шаардсан бол ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;
- (в) тендерт оролцгчийг төлөөлж ТОӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;

- (г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
- (д) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
- (е) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;
- (ё) ТШӨХ-д шаардсан ТОӨЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.

**13. Тендерийн маягт болон үнийн хуваарь**

13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөхгүй-гээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.

13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.

**14. Хувилбарт тендер**

14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.

**15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт**

15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.

15.2. Үнийн хуваарыт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.

15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.

15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.

15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхэлэн гаргасан Incoterms-ийн хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.

15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарыт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн

тендерийн үнэд багтаасан байна.

15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТОӨЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаас үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендерт оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендерувилбарХылбо ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

15.9. Унийн хуваарыт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

(а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:

1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;
2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;
3. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:

1. ТШӨХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;
2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;
3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл /эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;
2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;
3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;
4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

5. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчилөхөөр санал болгосон аливаа тендерийг ТОӨЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

15.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

**16. Тендерийн валют**

16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.

**17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**

17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:

- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
- (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
- (в) ТШӨХ-д шаардсан эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тусгай зөвшөөрөл;

**18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**

18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:

- (а) Хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлэгүй эм, эмнэлгийн хэрэгсэл тендерт санал болгох тохиолдолд уг эм, эмнэлгийн хэрэгслийг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр булэг дэх тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;
- (б) санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн баталгаажсан санхүүгийн тайлан;
- (в) гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
- (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
- (д) Хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх,

эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;

- (е) гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотолсон бичиг баримт (үүнд зээл авах болон санхүүгийн бусад эх үүсвэрийн боломжийг оролцуулж болно);
- (ë) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
- (ж) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
- (з) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.

18.2. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тухай гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үүнд:

- (а) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
- (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- (д) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

18.3. Тендерт оролцогч 18.2(а) ба (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ.

Гэхдээ гишүүн тус бүр 18.2 (а), (г) -д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлеөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагуудыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана.

ТШӨХ-д өөрөөр заагаагүй тохиолдолд тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, нөөц бололцоог харгалзан үзэхгүй.

Тендерт оролцогч 18.2(б) ба (в)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмж тооцно.

- 18.4. ТШӨХ-д тусгайлан заасан бол Монгол Улсын гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэлд 10 хувийн давуу эрх олгоно. Монгол Улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлж буй тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлтэй бол энэ тухайгаа нотлоход шаардлагатай баримт, материалыг тендертэй хамт ирүүлэх үүрэгтэй.
- 19. Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт**
- 19.1. ТОӨЗ-ны дагуу тендерт оролцогч гэрээний дагуу нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нь захиалагчийн шаардлагад нийцэх тухай нотлох баримтуудыг тендерийн хамт ирүүлнэ.
- 19.2. Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл нь эрх бүхий болохыг нотлох баримт болгож санал болгож буй барааны гарал үүслийг үнийн хуваарыт дурдах бөгөөд бараа тээвэрлэх үед гарал үүслийн сертификат эсхүл барааны гарал үүслийг нотлох бусад баримт бичиг ирүүлнэ.
- 19.3. Нийлүүлэх бараа тендерийн баримт бичигт нийцэж буйг нотлох баримт нь тухайн барааны дээж, нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:
- (а) барааны техникийн болон ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;
- (б) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн тухай мэдэгдэл;
- (в) ТШӨХ-д заасны дагуу бусад шаардагдах баримт
- 19.4. Гэрээний дагуу нийлүүлэх эм нь Монгол улсын эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн байна. Эмнэлгийн хэрэгслийн хувьд түүний сертификатыг хавсаргасан байна.
- 19.5. Захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материалын стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч ТОӨЗ-ны 19.3 (б)-ийн дагуу тайлбар ирүүлнэ. Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.
- 20. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангагүй тендер гэж үзэж, татгалзана.
- 21. Тендерийн баталгаа**
- 21.1. Тендерт оролцогч нь ТШӨХ-д заасан үнийн дүнтэй тэнцэх тендерийн баталгааг ирүүлнэ.
- 21.2. Тендер шалгаруулалт олон багттай бол нэг тендерийн баталгаа гаргаж, түүнд багц тус бүрээр тодорхойлж ирүүлнэ.
- 21.3. Захиалагч тендерийн баталгааны хэмжээг багц тус бүрийн төсөвт өртгийн 1-2 хувиар тооцож ТШӨХ-д заана.
- 21.4. Тендерийн баталгаа нь Монгол Улсын, эсхүл гадаадын нэр хүндтэй банкны гаргасан баталгаа, Засгийн газрын бонд эсхүл Засгийн газраас хүлээн зөвшөөрсөн үнэт цаасны хэлбэрээр байж болно. Тендерийн

баталгааг 4 дүгээр бүлэг дэх маягтаар, эсхүл тендер хүлээн авахаас өмнө захиалагч урьдчилан хүлээн зөвшөөрсөн маягтаар ирүүлнэ. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 21.5. Тендерийн баталгааны эх хувийг ирүүлэхдээ захиалагчийн ТШӨХ-д заасан хоног (он, сар, өдөр)-оор тооцож ирүүлнэ.
  - 21.6. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
  - 21.7. Энэ зүйлд шаардсаны дагуу хүлээн зөвшөөрөхүйц тендерийн баталгаа ирүүлээгүй аливаа тендерээс захиалагч үндсэн шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.
  - 21.8. Тендер нь шалгараагүй оролцогчийн тендерийн баталгааг 20.1-д заасан тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногт багтаан хүчингүй болгоно.
  - 21.9. Тендер нь шалгарсан оролцогчийн тендерийн баталгааг ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурж, ТОӨЗ-ны 42 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн тохиолдолд хүчингүй болгоно.
- 21.10. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд:
- (а) тендер нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан, эсхүл буцааж авахыг бичгээр мэдэгдсэн;
  - (б) тендерт оролцогч 32.2-ын дагуу тендерийн үнэд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрөгүй бөгөөд ТОӨЗ-ын 38.2-т заасан нөхцөл үүссэн бол;
  - (в) шалгарсан тендерт оролцогч заасан хугацаанд багтаан:
    - (1) ТОӨЗ-ны 41 дүгээр зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зураагүй;
    - (2) ТОӨЗ-ны 42 дугаар зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй.

**22. Тендер ирүүлэх хувь, тендерт гарын үсэг зурах**

- 22.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд “ЭХ ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Тендерт оролцогч үүнээс гадна ТШӨХ-д заасан тоо ширхэг бүхий тендерийн хуулбар хувийг бэлтгэн хавтаслаж “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн тодорхой бичиглэл хийнэ. Эх хувь болон хуулбар хувиуд хоорондоо зөрчилдсөн тохиолдолд эх хувийг баримтална.
- 22.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг бичиг баримт үүнд хамаарахгүй.

- 22.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

- 23. Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх**
- 23.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.
- 23.2. Тендерийн эх болон хуулбар хувиудыг тус тусад нь “ЭХ ХУВЬ”, “ХУУЛБАР ХУВЬ” гэсэн бичиглэл бүхий дугтуйнд хийж битүүмжлэн тэдгээрийг дахин давхар нэг дугтуйнд (гаднах) хийж битүүмжилнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТОӨЗ-ны 23.3, 23.4 –т заасныг баримтална.
- 23.3. Доторх ба гаднах дугтуйнууд дараах шаардлагыг хангасан байна.  
Үүнд:
- (а) тендерт оролцгчийн нэр, хаягтай байх;
  - (б) ТШӨХ-д заасан хаягаар ТОӨЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;
  - (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТОӨЗ-ны 1.1 болон ТШӨХ-д тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;
  - (г) ТОӨЗ-ны 28.1-т заасан хугацаанаас өмнө “НЭЭЖ ҮЛ БОЛНО” гэж тэмдэглэгдсэн байх.
- 23.4. Хэрэв бүх дугтуйг 23.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 23.5. ТОӨЗ-ны 23.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.
- 24. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 24.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 24.2. Захиалагч ТОӨЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан тохиолдолд захиалагч болон тендерт оролцгчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.
- 25. Хугацаа хоцорсон тендер**
- 25.1. Захиалагч ТОӨЗ-ны 24 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
- 26. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 26.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролзоходо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
- 27. Тендерт нэмэлт**
- 27.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө

**өөрчлөлт хийх,  
тендерийг  
буцааж авах**

захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.

- 27.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 22, 23 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт доторх ба гаднах дутгуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.
- 27.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 27.4. ТОӨЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.
- 27.5. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас тендер хүчинтэй байх хугацааны хооронд тендерийг буцааж авах нь 21 дүгээр зүйлийн дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох үндэслэл болно.

---

## **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

---

**28. Тендерийн  
нээлт**

- 28.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлаачаа эрхтэй ба байлаасан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.
- 28.2. Захиалагч эхлээд “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл бүхий дутгуйг нээж, зарлах бөгөөд энэ хүсэлтийг ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаана. Дараа нь “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ” бичиглэл бүхий тендерийг нээж зарлах бөгөөд уг тендерийг ирүүлсэн оролцогчийн урьд ирүүлсэн тендерийг нээлгүйгээр түүнд буцаан олгоно. “ТЕНДЕРТ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” бичиглэл бүхий дутгуйг түүнд харгалзах үндсэн тендерийн хамт нээж нийтэд зарлана.
- 28.3. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд түүний үнэ, тендерийн баталгаа байгаа эсэх, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.
- 28.4. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:
  - (а) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
  - (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт (зөвшөөрсөн бол хувилбарт тендерийн үнэ). Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц

тус бүрээр гаргах;

- (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх.

## 29. Нууцлал

- 29.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 29.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.
- 29.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

## 30. Тендерийн тодруулга

- 30.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний ирүүлсэн тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Энэ хүсэлт болон түүний хариултыг бичгээр үйлдэнэ.

Гэхдээ 31 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.

## 31. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох

- 31.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө дараахь шаардлагыг хангаж буйг хянан үзнэ. Үүнд:
- (а) ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
- (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж баталгаажуулсан эсэх;
- (в) зөвшөөрөгдсөн маягтын дагуу захиалагчийн шаардлагад нийцсэн тендерийн баталгаа ирүүлсэн эсэх;
- (г) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
- (д) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварыг хангасан эсэх.

- 31.2. ТОӨЗ-ны 31.1 дэх заалтын (а) - (д)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.

- 31.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзول, ялангуяа тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн чадвар, санал болгосон бараа нь ТОӨЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр биелүүлсэн тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ:

- (а) техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;

(б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендериин баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;

(в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендериин өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.

31.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.

### **32. Алдааг залруулах**

32.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж тоог засварлах;

(б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;

(в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийг байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

32.2. Захиалагч, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.

### **33. Нэг валютад хөрвүүлэх**

33.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол банкнаас албан ёсоор зөвшөөрсөн тохиолдол ТОӨЗ-ны 16 дугаар зүйлд зааснаас өөр валютаар тендерийн үнийг илэрхийлж болно. Ийм тохиолдолд захиалагч тендерийн үнэлгээ, харьцуулалтыг хийхдээ тендерийн үнийг тендер зарласан өдрийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

### **34. Дотоодын тендерт оролцогчид давуу эрх**

34.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй эм, эмнэлгийн хэрэгсэл санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.

### **35. Тендерийг үнэлэх, харьцуулах**

35.1. Захиалагч зөвхөн 31 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.

35.2. Захиалагч тендерийг үнэлэхдээ дараах байдлаар тендерийн үнэд залруулга хийж, тендерийн харьцуулах үнийг тодорхойлно:

(а) 32 дугаар зүйлийн дагуу арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах;

(б) 31 дүгээр зүйлийн дагуу томоохон зөрүү гэж тооцогүй бага хэмжээний орхигдуулсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцож, үнэд залруулга хийх;

- (в) тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах;
- (г) Захиалагч энэ ТББ-ийн 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг холбогдох аргачлалын дагуу тооцож тендерийн үнэд тусгах;
- (д) ТШӨХ-д зөвшөөрснөөр дотоодын давуу эрхийн зөрүү олгох бол холбогдох аргачлалын дагуу тооцох.

35.3. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 35.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэ ( $P_{min}$ )-тэй тендерт 70 оноо ( $S_{max}$ ) өгч, бусад тендерт оролцогчийн харьцуулах үнэ ( $P_x$ )-д харгалзах оноог дараахь томьёогоор бодно.

$$S_x = \frac{P_{min}}{P_x} \cdot S_{max}$$

$P_{min}$  – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендер оролцогчийн үнэ

$P_x$  – Тухайн тендерт оролцогчийн үнэ

$S_x$  – Тухайн тендерт оролцогчийн оноо

$S_{max}$  – Хамгийн бага харьцуулах үнэтэй тендер оролцогчийн оноо

35.4. Чанарын үнэлгээг дараахь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

35.4.1. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын урьдчилан баталгаажуулалтад орсон бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;

$50 \leq 60\% - 1$  оноо;

$60 \leq 70\% - 2$  оноо;

$70 \leq 80\% - 3$  оноо;

$80 \leq 90\% - 4$  оноо;

$90 \leq 100\% - 5$  оноо;

35.4.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй бол (SRA):

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;

$50 \leq 60\% - 1$  оноо;

$60 \leq 70\% - 2$  оноо;

$70 \leq 80\% - 3$  оноо;

$80 \leq 90\% - 4$  оноо;

$90 \leq 100\% - 5$  оноо;

35.4.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь чөлөөт худалдааны гэрчилгээтэй бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;

$50 \leq 60\% - 1$  оноо;

$60 \leq 70\% - 2$  оноо;

$70 \leq 80\% - 3$  оноо;

$80 \leq 90\% - 4$  оноо;

$90 \leq 100\% - 5$  оноо;

35.4.4. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь Англи, Америк, Европын фармакопейн шаардлага хангасан нотлох баримт ирүүлсэн бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;  
 $50 \leq 60\% - 1$  оноо;  
 $60 \leq 70\% - 2$  оноо;  
 $70 \leq 80\% - 3$  оноо;  
 $80 \leq 90\% - 4$  оноо;  
 $90 \leq 100\% - 5$  оноо;

- 35.4.5. Эм, эмнэлгийн хэрэгслийг тендерт оролцогч үйлдвэрлэдэг бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;  
 $50 \leq 60\% - 1$  оноо;  
 $60 \leq 70\% - 2$  оноо;  
 $70 \leq 80\% - 3$  оноо;  
 $80 \leq 90\% - 4$  оноо;  
 $90 \leq 100\% - 5$  оноо;

- 35.4.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд тендерт оролцогч импортлодог бол:

Тухайн багцын:

$0 \leq 50\% - 0$  оноо;  
 $50 \leq 60\% - 1$  оноо;  
 $60 \leq 70\% - 2$  оноо;  
 $70 \leq 80\% - 3$  оноо;  
 $80 \leq 90\% - 4$  оноо;  
 $90 \leq 100\% - 5$  оноо;

- 35.5. Дотоодын үйлдвэрлэгч 35.4.2, 35.4.3 дахь хэсэгт заасан гэрчилгээ-тэй гэж үзэн харгалзах оноог өгнө.

- 35.6. Чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноог 35.3, 35.4-д заасны дагуу тооцох ба харьцуулах үнэ болон чанарын үнэлгээнд харгалзах онооны нийлбэрээр хамгийн өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ.

$$B_x = Q_x + S_x$$

$B_x$  – Тухайн тендерт оролцогчийн чанар ба үнэлгээний харьцуулалтын нийт оноо

$Q_x$  – Тухайн тендерт оролцогчийн чанарын үнэлгээний оноо

- 35.7. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

- 35.8. Барааг ТОӨЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгоходо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.

- 35.9. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгоходо захиалагч З дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэх олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

## 36. Тендерт оролцогчийн

- 36.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин

<b>чадварыг дахин магадлах</b>	магадлаж болно.
	<p>36.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлоходоо ТОӨЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТОӨЗ-ны 30 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТОӨЗ-ны 18.2-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.</p> <p>36.3. “Хамгийн сайн” үнэлгэдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлгэдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.</p>
<b>37. Аливаа тендерийг сонгож, эсхүл тендерүүдээс татгалзах</b>	<p>37.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.</p>

## **E. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

<b>38. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур</b>	<p>38.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 35.6-д заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлгэдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.</p> <p>38.2. “Хамгийн сайн” үнэлгэдсэн тендер ирүүлсэн оролцогч ТОӨЗ-ны 32 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөгүй бол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзах бөгөөд 21.9(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгоно.</p>
<b>39. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл</b>	<p>39.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.</p> <p>39.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (туүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> <p>39.3. Захиалагч засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a> вэб сайтад тендерийн нэр болон багцын дугаарыг дараах мэдээллийн хамтаар гэрээ байгуулах эрх олгосон даруй нийтэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>(1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;</li> <li>(2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;</li> <li>(3) Нарийвчлан үнэлгэдсэн тендерийн нэр, үнийн санал;</li> <li>(4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;</li> <li>(5) Тендер нь шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон тендерийн үнэ, гэрээний үнийн дүн.</li> </ul> <p>39.4. Тендер нь шалгарсан оролцогч ТОӨЗ-ын 42 дугаар зүйлийн дагуу</p>

гаргасан гүйцэтгэлийн баталгаа болон гэрээний маягтанд гарын үсэг зурж ирүүлсний дараагаар захиалагч ТОӨЗ-ын 21.8-д заасны дагуу тендерийн баталгааг хүчингүй болгож байгаа тухай шалгараагүй бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

- 40. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо хэмжээг өөрчлөх**
- 40.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.
- 41. Гэрээнд гарын үсэг зурах**
- 41.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 41.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
- 41.3. Захиалагч шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсний дараа ТОӨЗ-ны 39.2-т нийцүүлэн гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 42. Гүйцэтгэлийн баталгаа**
- 42.1. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанд багтаан, ТШӨХ, гэрээний тусгай нөхцөлд тусгайлан заасан хэлбэр, дүнгээр ирүүлнэ.
- 42.2. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно.
- 42.3. Шалгарсан тендерт оролцогч ТОӨЗ-ны 42.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох болон тендерийн баталгааг гүйцэтгүүлэх үндэслэл болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгсэл талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа /ТОӨЗ-/ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>A. Ерөнхий зүйл</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	Захиалагч нь: <b>ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	Нээлттэй тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>ЭСҮТ/201901007</b>
<b>ТОӨЗ 1.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Нийт баат</b>
<b>ТОӨЗ 2.1</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөөв</b>
	<b>B. Тендерийн баримт бичиг</b>
<b>ТОӨЗ 8.1</b>	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Эмгэг судлалын үндэсний төв 2 давхар 14 тоот,</b> <b>Утас:11313820</b>
<b>ТОӨЗ 8.1</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <b>5 хоногоос багагүй байна.</b>
	<b>C. Тендер бэлтгэх</b>
<b>ТОӨЗ 11.1</b>	Хэрэв тендерт гадаадын этгээд оролцох эрхтэй бол тендерийн хэл нь Монгол хэлээс гадна дараах хэл дээр байна. Уүнд: Монгол хэл
<b>ТОӨЗ 12.1 (а) – (ё)</b>	12.1 (а) - (ё)-д заасан баримт бичгээс гадна дараах материалыг нэмжжүүлнэ <ol style="list-style-type: none"><li><b>1. Хуулийн этгээдийн гэрчилгээ ирүүлнэ.</b></li><li><b>2. Үндэсний татварын албаны тодорхойлолт ирүүлнэ</b></li><li><b>3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт</b></li><li><b>4. Эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх улс, үйлдвэрлэгчийг тодорхой зааж баталгааг ирүүлнэ.</b></li><li><b>5. Эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд загвар дээж, каталоги ирүүлнэ./Спирт 96%, эс ба эдийн үндсэн будгууд, буффер саармаг формалин, ксилол зэрэг бүтээгдэхүүнд дээж, бусад бүтээгдэхүүнд каталоги ирүүлэх/</b></li><li><b>6. Баримт бичиг нь гадаад хэл дээр байх тохиолдолд албан ёсны баталгаажсан орчуулгын товчоогоор Монгол хэлээр орчуулсан байна. /Уүнд: албан ёсны дистрибутерийн эрх, түнилэлийн</b></li></ol>

	<p><i>гэрээ, импортын гэрээ/</i></p> <p><b>7. Эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнд үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, гэрээний хуулбар</b></p> <p><b>8. Нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн бүтээгдэхүүний олон улсын сертификат</b></p> <p><b>9. Эм, эмнэлгийн хэрэгсэл нь техникийн тодорхойлолтод тусгайлан заагдсан стандартуудыг болон ДЭМБ-ын GMP, ISO шаардлагын аль нэгийг хангасан байна. /Thermo scientific г.м олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компаниййн бүтээгдэхүүнтэй дүйцэхүйц/</b></p> <p><b>10. Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалжс бодис нийлүүлэх тусгай зөвшөөрөл</b></p>
<b>ТОӨЗ 14.1</b>	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
<b>ТОӨЗ 15.5</b>	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: “ <i>Incoterms 2010</i> ”
<b>ТОӨЗ 15.9 (б) (1) and (в) (3)</b>	Бараа хүргэгдэх газар: “ <i>Эмгэг Судлалын Үндэсний Төв</i> ”
<b>ТОӨЗ 15.9 (а) (3);(б)(3) болон (в)(5)</b>	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: <i>Эмгэг Судлалын Үндэсний Төвийн лабораторын агуулах</i>
<b>ТОӨЗ 15.9 (б) (1)</b>	Монгол Улсын хилээс гадна үйлдвэрлэгдэх барааг нийлүүлэх үнэ нь ТОӨЗ-ны 15.9.(б).(1) дэх хэсэгт заасан CIP үнэ байна.
<b>ТОӨЗ 15.10</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “ <i>тохируулахгүй тогтолцол байна.</i> ”
<b>ТОӨЗ 16.1</b>	Тендерийн валют: <i>Төгрөг байна.</i>
<b>ТОӨЗ 18.1 (а)</b>	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “ <i>шаардлагатай</i> ”
<b>ТОӨЗ 18.1 (б)</b>	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>[2017,2018].</i>
<b>ТОӨЗ 18.1 (г)</b>	Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: <i>[2017,2018]</i>
<b>ТОӨЗ 18.1 (д)</b>	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “ <i>шаардлагатай</i> ”
<b>ТОӨЗ 18.2 (а)</b>	Борлуулалтын хэмжээ: <i>Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь санал болгож буй нийт үнийн дүнгийн 50 % -иас багагүй байна.</i>
<b>ТОӨЗ 18.2 (б)</b>	Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <i>[2017,2018].</i>
<b>ТОӨЗ 18.2 (в)</b>	Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: “ <i>шаардлагагүй</i> ”
<b>ТОӨЗ 18.2 (г)</b>	Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: <i>Санал болгож буй багцын нийт үнийн дүнгийн 50%-тай тэнцэх</i>

<b>ТОӨЗ 18.2 (д)</b>	Ашигтай ажилласан байх жилийн тоо: <b>1 жил</b>
<b>ТОӨЗ 18.4</b>	Дотоодын давуу эрхийн зөрүү: “ <b>мооцно</b> ”
<b>ТОӨЗ 19.1.(б)</b>	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе: <b>Нийлүүлэлтийн хуваарийн дагуу</b>
<b>ТОӨЗ 20.1</b>	Тендер нээснээс хойш <b>45</b> хоногийн туршид хүчинтэй байна.
<b>ТОӨЗ 21</b>	Тендерийн баталгааны үнийн дүн: <b><a href="http://www.tender.gov.mn-ээс">www.tender.gov.mn-ээс</a> харна уу.</b> Хүчинтэй байх хугацаа: 2019 он 03 сар 29 өдөр
<b>ТОӨЗ 22.1</b>	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>Г. Тендер ирүүлэх</b>
<b>ТОӨЗ 23.3 (б)</b>	Тендер хүлээн авах захиалгчийн хаяг: <b>Эмгэг Судлалын Үндэсний Төв 14 тоот</b> Тендер хүлээн авах этгээд: <b>Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн ажилтан У.Отгончимэг</b> Байгууллагын хаяг: <b>СБД, 1-р хороо, Эмгэг Судлалын Үндэсний Төв</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Санхүү эдийн засгийн алба 14 тоот</b> Аймаг, хот: <b>Улаанбаатар</b> Шуудангийн дугаар: Улс: <b>Монгол улс</b>
<b>ТОӨЗ 23.3 (в)</b>	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргагтай тэмдэглэнэ: <b>Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис худалдан авах</b> Тендер шалгаруулалтын дугаар: <b>ЭСҮТ/201901007</b>
<b>ТОӨЗ 24.1</b>	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09 цаг 00 мин</b> <b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>
<b>ТОӨЗ 28.1</b>	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>СБД, 1 дүгээр хороо, С.Зоригийн гудамж, Эмгэг Судлалын Үндэсний Төв</b> Давхар болон өрөөний дугаар: <b>2-р давхар, Хурлын танхим 12 тоот</b> Аймаг, хот: <b>Улаанбаатар</b> Шуудангийн дугаар: Улс: <b>“Монгол Улс”</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2019 оны 02 дугаар сарын 15-ны өдөр</b>

	Цаг: <b><i>09 цаг 30 минут</i></b>
	<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>
<b>ТОӨЗ 40.1</b>	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b><i>30%</i></b> Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b><i>30%</i></b>

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

#### (а) Гэрээний болон арилжааны зөрүү: “*Ашиглахгүй*”

Гэрээний болон худалдааны нөхцөлөөс зөрүүтэйгээр санал болгосон болон орхигдуулсан зүйл бүрийн өргтийг тооцоолж үнэлгээнд харгалзана. (Гэхдээ дээрх зөрүү нь захиалагчийн хүлээн зөвшөөрөхүйц жижиг хэмжээний зөрүү, орхигдуулсан зүйл, тоо ширхэгтэй холбоотой байж болох бөгөөд захиалагч түүнийг томоохон зөрүү гэж үзсэн тохиолдолд уг тендерээс татгалзах эрхтэй.)

#### (а) Бараа нийлүүлэлтийн хуваарь: “*Ашиглана*”

Тухайн тендер шалгаруулалтанд холбогдох гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь нийлүүлэлтийн хуваарь (Бүлэг 6)-т заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (барааны нийлүүлэлт хийх хамгийн эхний өдрөөс хойш нийлүүлэлт хийвэл зохих хамгийн сүүлчийн өдрийг оролцуулан) нийлүүлэгдсэн байх шаардлагатай. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанаас өмнө нийлүүлэх санал бүхий тендерт урамшуулал буюу үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл байдал олгохгүй.

Захиалагч ТШӨХ-д тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд бараа нийлүүлэлтийн хуваарьт зааснаас хоцорч нийлүүлэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд тендерийн үнийн ТШӨХ-д заасан **0,05%**-иар тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

Барааг хуваарьт зааснаас ТШӨХ-д заасан **3 сараас** илүү сар хоцроож хүргэхийг санал болгосон тендерээс татгалзана. Харин ТШӨХ-д захиалагч тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон бараа нийлүүлэлтийн хуваариас хойш нийлүүлэхээр санал болгосон тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

#### (б) Төлбөрийн хуваарийн зөрүү. “*Ашиглахгүй*”

##### (в) Тендерийн дагуу санал болгож байгаа бараа (тоног төхөөрөмж)-ны гол эд анги, зайлшигүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: “*Ашиглахгүй*”

##### (г) Тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн байгаа улсад үзүүлэх боломж: “*Ашиглахгүй*”

ТШӨХ-ийн 35.2 (г)-д тусгайлан заасан бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн нийт үнэ дээр нэмж тохируулга хийнэ.

##### (д) Тендерийн дагуу санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны ашиглалтын болон хэвийн ажиллагааг хангахад шаардагдах зардал: “*Ашиглахгүй*”

##### (е) Тендерт санал болгосон бараа (тоног төхөөрөмж)-ны үр ашиг болон үйл ажиллагааны баталгаа: “*Ашиглахгүй*”

##### (ё) Барааны дотоодын тээвэрлэлт, даатгал болон бусад зардал: “*Ашиглахгүй*”

## **Олон багцтай тендерийг үнэлэх**

ТОӨЗ-ны 35.6-д заасны дагуу захиалагч нэг ба түүнээс дээш багцаар гэрээ байгуулах эрхтэй бол олон багцыг үнэлж гэрээ байгуулах эрх олгоход дараах аргачлалыг мөрдөнө.

Захиалагч багцуудын хамгийн сайн үнэлэгдсэн буюу хамгийн үр ашигтай байх хувилбарыг дараах байдлаар сонгоно. Үүнд:

- (a) ТОӨЗ-ны 15.8-д зааснаар багц тус бүрт байх барааны нэр төрөл болон нэр төрөл тус бүрийн тоо хэмжээ нь бүрэн бол тухайн багцад үнэлгээ хийнэ.
- (b) Үнэлгээнд дараах журмыг баримтална:
  - (i) багц тус бүрт үнэлгээний шалгуурыг хангасан хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг тогтоох;
  - (ii) тендерт оролцогчийн тухайн хамгийн сайн үнэлэгдсэн тендерт санал болгосон үнийн хөнгөлөлтийг санал болгосон аргачлалын дагуу багц тус бүрт тооцох;
  - (iii) эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай байх хувилбараар гэрээ байгуулах эрх олгохоор сонгох. Ингэхдээ нэг тендерт оролцогч 2 ба түүнээс дээш багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн бол түүний гэрээг хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаж тогтооно. Хэрвээ тухайн оролцогч 2-оос дээш багцад гэрээ хэрэгжүүлэх чадвар нь хангалтгүй гэж үнэлэгдвэл түүний чадавхид тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАЯГТ №: ТШМ-1

## ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэрийг оруул], энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн [бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]-г [тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
- Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш [моо] хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарыт үндэслэнэ.
- Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт [үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах] [Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул] үзүүлнэ.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [моо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолтгүй болохоо мэдэгдэж байна.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

МАЯГТ №: ТШМ-2А

**МОНГОЛ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭГДСЭН  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(А ангилал)

Огноо: \_\_\_\_\_

НТШ-ын дугаар: \_\_\_\_\_

Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_

Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_

Хуудасны \_\_\_\_ -ын \_\_\_\_ дугаар \_\_\_\_

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг болон эд анги	EXW нэгж үнэ	Нэр төрөл бүрийн EXW бүгд үнэ (4x5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9.(а).(3)-д шаардсан бол)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөгийн 6-р баагад заасан үнэд эзлэх хувь	ТОӨЗ-ны 15.9.(а).(2)-д заасан гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (6+7+9)
<b>Тендерийн нийт үнэ (10)</b>									

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

МАЯГТ №: ТШМ -2Б

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРЖ ИРЭХ  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(Бангилал)

Огноо: \_\_\_\_\_

НТШ-ын дугаар: \_\_\_\_\_

Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_

Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_

Хуудасны \_\_\_\_\_ -ын \_\_\_\_\_

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Тоо ширхэг	ТОӨЗ-ны 15.9 (б) (1)-д заасан СИФ эсхүл СИП нэгж үнэ	Нэр төрөл бүрийн СИФ эсхүл СИП нийт үнэ (4 x 5)	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (хэрэв ТШӨХ, ТОӨЗ-ны 15.9(б).(3)-д шаардсан бол)	ТОӨЗ-ны 15.9(б).(2)-д зааснаар гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрлийн нийт дүн (6 + 7+8)
Тендерийн нийт дүн (9)								

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

**МОНГОЛ УЛСЫН ГАДНА ҮЙЛДВЭРЛЭГДСЭН БӨГӨӨД ИМПОРТООР ОРУУЛЖ ИРСЭН  
БАРААНЫ ҮНИЙН ХУВААРЬ**

(В ангилал)

Огноо: \_\_\_\_\_  
 НТШ-ын дугаар: \_\_\_\_\_  
 Тендерийн урилгын дугаар: \_\_\_\_\_  
 Хувилбарт тендерийн дугаар: \_\_\_\_\_  
 Хуудасны \_\_\_\_\_ -ын \_\_\_\_\_

ТОӨЗ-ны 16-д заасан валютаар

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Нэр төрөл №	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	Инкотермд тусгасны дагуу хүргэх огноо	Тоо ширхэг	ТОӨЗ-ны 15.9 (в) (1)-д заасан урьд нь төлсөн болон төлөх гаалийн татвар хураамж болон импортын татварыг оруулсан нэгж үнэ	ТОӨЗ-ны 15.9 (в). (2)-д заасан нэр төрөл бүрт төлсөн гаалийн болон импортын татвар хураамж [нотлох бичиг баримтыг үндэслэнэ]	ТОӨЗ-ны 15.9 (в) (3)-д заасны дагуу нэгж үнэ (гаалийн татвар хураамж болон импортын татварыг хассан) (6 – 7)	ТОӨЗ-ны 15.9 (в) (3) (9=8x5)-д заасны дагуу гаалийн болон импортын татварыг хассан нэр төрөл бүрийн үнэ	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ (ТОӨЗ-ны 15.9 (в) (5)-д шаардсан бол)	Гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	Нэр төрөл бүрийн нийт үнэ (9+10+11)
<b>Тендерийн нийт үнэ (12)</b>											

Тендерт оролцогчийн нэр \_\_\_\_\_ Гарын үсэг \_\_\_\_\_ Огноо \_\_\_\_\_

3. ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ  
(БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн<sup>1</sup> төлбөр хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
2. захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
  - (a) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
  - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
  - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ.

Энэхүү баталгаа нь *[огноог оруул]* өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстай.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:  
Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

<sup>1</sup> Баталгааны дүнг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дүн нь тендерт оролцогчдод егех зааварчилгааны 21.1-д заасантай ижил байна.

ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ  
(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[*Тендерт оролцогчийн нэр*] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [*Тендерт шалгаруулалтын нэр*] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн<sup>2</sup> төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчын засгийн газрын бондыг<sup>3</sup> үндэслэн батлан даалт гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (2) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
3. захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
  - (a) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
  - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
  - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж дээр зааснаас хэтрэхгүй мөнгөн дүнтэй тэнцэх төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ.

Энэхүү баталгаа нь [*огноог оруул*] өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгаатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банк/Биржийн тамга:

Огноо:

Хаяг:

<sup>2</sup> Баталгааны дунг тендерийн, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөстэй хөрвөх валютаар илэрхийлж, үсгээр болон тоогоор заана. Энэ дун нь тендерт оролцогчдод егех зааварчилгааны 21.1-д заасантай ижил байна.

<sup>3</sup> Засгийн газрын бондын эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-с доошгүй сарын дараа байна.

## ҮЙЛДВЭРЛЭГЧ/ГЭРЭЭТ БОРЛУУЛАГЧИЙН ИТГЭМЖЛЭЛ

[Тендерт оролцогч энд заасан зааврын дагуу үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчаар энэ маягтыг бөглүүлсэн байна. Энэхүү итгэмжлэлийг үйлдвэрлэгч/гэрээт борлуулагч ийн албан бланкан дээр бичиж, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан байна. ТШӨ-д шаардсан тохиолдолд тендерт оролцогч үүнийг тендерийн хамт ирүүлнэ.]

Огноо: [тендер ирүүлсэн (өдөр, сар, он)]

НТШ-ын дугаар: [оруул:тендер шалгаруулалтын дугаар]

Хувилбарын дугаар: [оруул:энэнь хувилбарт тендер бол ялгах дугаар]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

Бид, [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүтэн хаяг]-д байршилтай [оруул: үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн бүрэн нэр] нь [оруул: үйлдвэрлэдэг/ борлуулдаг барааны төрөл]-ийг албан ёсоор үйлдвэрлэдэг/ борлуулдаг бөгөөд, үүгээр [оруул: тендерт оролцгчийн бүтэн нэр] компанид бидний үйлдвэрлэсэн/борлуулсан [оруул: барааны нэр ба товч тодорхойлолт], барааг санал болгосон тендер ирүүлж, улмаар хэлэлцээр хийн гэрээ байгуулахыг зөвшөөрч байна.

Бид дээр дурдсан компанийн санал болгосон барааны хувьд Гэрээний ерөнхий нөхцөлийн 14-д заасны дагуу чанарын баталгааг бүрэн гаргаж байна.

Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **5. Чадварын мэдээлэл ирүүлэх маягтууд**

МАЯГТ №: ТМ-5А

## **Санал болгож буй туслан гүйцэтгэгч**

## **Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага**

## Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр

Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө.

**Нэгдсэн хүснэгт: Одоо хэрэгжиж буй гэрээ**

Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр
--

Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр өөрсдийн хэрэгжүүлж буй буюу одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээг дуусгахаар төлөвлөсөн хугацаа	Дараагийн 6 сард нэхэмжлэх үнийн дүнгийн сарын дундаж
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Санхүүгийн чадавхи

**Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүний нэр**

Тендерт оролцогч түншлэлийн гишүүн бүрийг оролцуулан ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг хангаж буйг харуулсан санхүүгийн мэдээллийг ирүүлнэ. Тендерт оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр энэ маягтын дагуу өөрийн холбогдох мэдээллийг ирүүлнэ. Шаардлагатай бол банкны мэдээллийн хүснэгтийг тус тусдаа бөглөнө. Татварын албандаа тушаасан (Захиалагч шаардсан бол аудитаар баталгаажуулсан байх) санхүүгийн тайланг нотлох баримт болгон энд хавсаргана.

<b>Банк</b>	<b>Банкны нэр</b>	
	<b>Банкны хаяг</b>	
	<b>Утас</b>	Холбоо барих ажилтны нэр, албан тушаал
	<b>Факс</b>	Телекс

Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацааны нийт хөрөнгө болон эх үүсвэрийг төгрөгөөр илэрхийлнэ.

Санхүүгийн мэдээлэл /ам.доллараар/	Сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд						Төлөвлөсөн: Дараагийн 2 жилийн хугацаанд
	5	4	3	2	1	1	
1. Нийт хөрөнгө							
2. Эргэлтийн хөрөнгө							
3. Нийт өглөг							
4. Эргэлтийн өглөг							
5. Татварын өмнөх ашиг							
6. Татварын дараах ашиг							

Санал болгож буй санхүүгийн эх үүсвэр буюу ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан шаардлагыг ханган гэрээг гүйцэтгэх явцад хүрэлцэхүйц эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэйг харуулсан хөрвөх хөрөнгө, зээл авах боломж буюу зээлжих баталгаажсан эрх болон бусад санхүүгийн хэрэгслийг тодорхойлно.

<b>Эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад эх үүсвэр</b>	<b>Дүн</b>
1.	
2.	
3.	

ТОӨЗ-ны 18.2 (а) заалт болон түүнд харгалзах ТШӨХ-д заасан хугацааны (тендер оролцогч эсхүл түншлэлийн гишүүн бүр) аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, түүнд хийсэн тайлбарыг хавсаргана.

Хэрэв тендерт оролцогчийн улсын хуулиар аудитын баталгааг шаарддаггүй бол хувийн байгууллагын санхүүгийн тайланг эрх бүхий бүртгэгдсэн нягтлан бодогч болон татварын байгууллагын тодорхойлолтын хуулбарыг хавсаргана.

**Ажиллах хүчний чадавхи**

Тендерт оролцогчийн нэр
-------------------------

Тендерт оролцогч нь гэрээний удирдлага болон хэрэгжилтийг хариуцан ажиллахтай холбогдох ур чадвар, мэргэжлийн шаардлагыг хангасан, хамгийн багадаа 2 хүний нэрийг албан тушаал тус бүрт дэвшигч бүрийн ажлын туршлагын талаарх мэдээллийг тус тусад нь гаргаж ирүүлнэ.

Тендерт оролцогч нь гэрээг удирдах, хэрэгжилтийн зохион байгуулах хувилбарт нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварын талаарх мэдээллийг мөн ирүүлнэ.

1.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
2.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
3.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр
4.	Албан тушаал
	Үндсэн нэр дэвшигчийн нэр
	Хувилбарт нэр дэвшигчийн нэр

## **Шинэчилсэн үнийн хуваарь**

Шинэчилсэн үнийн хуваарь нь (хэрэв өөрөөр заагаагүй бол) гэрээний нэг хэсэг болох бөгөөд нийлүүлэгчийн ирүүлсэн тендер дэх үнийн хуваариас ялгаатай байвал түүнийг орлоно. Энэ шинэчилсэн үнийн хуваарь нь ТОӨЗ-ны 18.3, 24.2, болон 33.1 дүгээр зүйлд заасны дагуу аливаа залруулга, тохируулгыг тусгана.

## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### ГАРЧИГ

1. Нэр томъёо
2. Үйлчлэх хүрээ
3. Барааны гарал үүслийн улс
4. Стандарт
5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах
6. Бүртгэлийн гэрчилгээ
7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх
8. Гүйцэтгэлийн баталгаа
9. Шалгалт болон туршилт
10. Баглаа боодол
11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
12. Даатгал
13. Дагалдах үзүүлчилгээ
14. Чанарыг баталгаа
15. Төлбөр
16. Үнэ
17. Захиалгыг өөрчлөх
18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
19. Гэрээний үүргийг шилжүүлэх
20. Гүйцэтгэлийн хугацааг сунгах
21. Алданги оногдуулах
22. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах
23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал
24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах
25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах
26. Маргааныг шийдвэрлэх
27. Гэрээнд ашиглах хэл
28. Гэрээнд мөрдөх хууль
29. Мэдэгдэл
30. Татвар болон бусад хураамж

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## 1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм, эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

## 2. Үйлчлэх хүрээ

2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.

## 3. Барааны гарал үүслийн улс

3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно

3.2 Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн газрыг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

## 4. Стандарт

4.1 Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь Техникийн тодорхойлолтод заагдсан стандартад нийцсэн байна. Тусгайлсан стандарт заагдаагүй

		тохиолдолд тухайн барааны гарал үүслийн улсын холбогдох стандартад нийцсэн байна. Энэ стандарт нь холбогдох байгууллагын хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хувилбар байна.
<b>5. Гэрээний баримт бичиг, мэдээллийг ашиглах, хяналт шалгалт явуулах</b>	5.1	Нийлүүлэгч нь захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд гэрээ ба түүний нөхцөл, эдгээртэй холбогдуулж захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолт, зураг, загвар, дээж зэрэг мэдээллийг гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтнаас бусад этгээдэд задлаж болохгүй. Гэрээг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг зөвхөн түүний хариуцсан ажилд шаардлагатай мэдээллээр хангана.
	5.2	Захиалагч бичгээр урьдчилан зөвшөөрөөгүй тохиолдолд, нийлүүлэгч ГЕН-ийн 5.1-т дурдсан баримт бичиг болон мэдээллийг гэрээ гүйцэтгэхээс бусад зорилгоор ашиглахгүй.
	5.3	ГЕН-ийн 5.1-т дурдсан гэрээнээс бусад баримт бичиг захиалагчийн өмч хэвээр үлдэх ба хэрэв захиалагч хүсвэл нийлүүлэгч гэрээний үүргээ гүйцэтгэж дуусмагц (бүх хувийг) захиалагчид буцааж өгнө.
	5.4	Захиалагч нийлүүлэгчийн гэрээний гүйцэтгэлд хамаарах данс, бүртгэлийг шалгах эрхтэй ба аудитор томилж эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийлгэх эрхтэй.
<b>6. Бүртгэлийн гэрчилгээ</b>	6.1	Гэрээгээр нийлүүлэгдэх эм нь Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн байна.
	6.2	Эмэнд бүртгэлийн гэрчилгээ аваагүй бол Монгол улсын хуулийн дагуу бүртгэгдсэн мэдэгдэлийг эрх бүхий этгээдээс авснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
<b>7. Зохиогчийн болон оюуны өмчийн эрх</b>	7.1	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>8. Гүйцэтгэлийн баталгаа</b>	8.1	Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан дүн бүхий гүйцэтгэлийн баталгаа гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор захиалагчид өгнө.
	8.2	Нийлүүлэгч гэрээний ажлаа дуусгаж чадаагүйгээс захиалагчид учрах хохирлыг нөхжөн барагдуулахад уг баталгаа зориулагдана. Гэрээний гүйцэтгэлийг ГЕН-ийн 20.2-ын дагуу сунгахад нийлүүлэгч мөн хугацаагаар гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй хугацааг сунгана.
	8.3	Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний, эсхүл захиалагч хүлээн зөвшөөрөх чөлөөтэй хөрвөх валютаар захиалагч хүлээн зөвшөөрөх дараах төрлийн баталгаа байна. Үүнд:
	(а)	Тендерийн баримт бичгийн Бүлэг VII-д заасан маягтаар гаргасан банкны баталгаа, эсхүл
	(б)	Засгийн газрын бонд эсхүл
	(в)	Засгийн газрын хүлээн зөвшөөрсөн үнэт цаас
	8.4	Нийлүүлэгч гэрээний ажлыг дуусгавар болгосноос хойш 30 хоногийн

		дотор захиалагч гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.
<b>9. Шалгалт болон туршилт</b>	9.1	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй.
		Гэрээний тусгай нөхцөлд эсвэл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгч(д)ийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
<b>10. Баглаа боодол</b>	10.1	Нийлүүлэгч барааг эцсийн цэг хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудахаас урьдчилан сэргийлэх баглаа боодлоор гэрээнд заасны дагуу хангана. Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн хатуу нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн болон гэрэл, чийг зэргийг хангалттай тэсвэрлэхээр байна. Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, түүнчлэн тээвэрлэлтийн цэг бүрт ачих буулгах хангалттай төхөөрөмж байхгүй зэргийг харгалзсан байна.
	10.2	Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ гэрээнд, түүний дотор гэрээний тусгай нөхцөлд заасан шаардлага болон захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг чанд мөрдөнө.
<b>11. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	11.1	Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч гэрээний тусгай нөхцөлд заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
	11.2	Гэрээнд хэрэглэсэн CIP /СИП/, EXW /ИКСБ/, FOB /ФОБ/, FCA/ФСА/, CIF /СИФ/ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>12. Даатгал</b>	12.1	Үйлдвэрлэх, худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах, болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдэлээс хамгаалж бүх барааг гэрээний тусгай нөхцөлд заасан хэлбэрээр даатгуулна.
<b>13. Дагалдах үйлчилгээ</b>	13.1	Нийлүүлэгч ГТН-д заасан дагалдах үйлчилгээг гүйцэтгэнэ.
	13.2	Хэрэв гэрээний үнэд тусгагдаагүй бол дагалдах үйлчилгээний зардлыг талууд харилцан тохиролцож нийлүүлэгчид төлнө. Энэ зардал нь захиалагчийн бусад гүйцэтгэгчид төлсөн ижил төстэй үйлчилгээний зардлаас хэтрэхгүй байна.
<b>14. Чанарын баталгаа,</b>	14.1	Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ үйлдвэрлэгдсэн, өмнө ашиглагдаагүй бөгөөд үйлдвэрлэсэн болон хүчинтэй байх хугацааг хангасан байна. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээ нь нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хадгалалтын хугацаатай барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй болохыг

нийлүүлэгч баталгаажуулна.

Мөн гэмтэл согогтгүй бөгөөд гэрээний нөхцөлүүд болон техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагаас чанарын шаардлага хангаагүй үндэслэлээр хэрэглээнээс хасагдаагүй, орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.

- 14.2 Захиалагч энэхүү баталгааны дагуу гарах гомдлыг нийлүүлэгчид бичгээр нийлүүлэгдсэнээс хойш 3 сарын дотор мэдэгдэнэ. Нийлүүлэгч энэхүү мэдэгдлийг хүлээн аваад гэмтэл согогтой барааг үнэ төлбөргүй солино.
- 15. Төлбөр**
- 15.1 Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг гэрээний тусгай нөхцөлд дурьдана.
- 15.2 Нийлүүлэгч нь гэрээгээр хүлээн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай бараа нийлүүлэлтийн гүйцэтгэлийг захиалагчид хүргүүлнэ. Уг гүйцэтгэлд нийлүүлсэн бараа үйлчилгээний нэхэмжлэх, ГЕН-ийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагатай баримт бичгийг хавсаргана.
- 15.3 Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор шуурхай хийнэ.
- 15.4 Гэрээний дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тендерийн маягтад дурдсан валютаар хийнэ.
- 16. Үнэ**
- 16.1 Гэрээний дагуу хүргэсэн бараа болон гүйцэтгэсэн үйлчилгээний үнийг нэхэмжлэхдээ нийлүүлэгч өөрийн тендерт санал болгосон үнийг баримтлана. Гэрээний тусгай нөхцөлийн үнэ тохируулах нөхцөлийн дагуу үнийг тохируулах, эсхүл ГЕН-ийн 17 дугаар зүйлийн дагуу захиалгыг өөрчлөхөд тендерт санал болгосон үнэ өөрчлөгдвэл, өөрчлөгдсөн үнийг баримтлана.
- 17. Захиалгыг өөрчлөх**
- 17.1 Захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээний өрөнхий цар хүрээнд багтаан дор дурдсан нэг буюу түүнээс дээш зүйлийн захиалгыг өөрчлөх эрхтэй:
- (а) гэрээний дагуу нийлүүлэгдэх барааг захиалагчид зориулан тусгайлан үйлдвэрлэсэн байхаар техникийн тодорхойлолтыг өөрчлөх;
- (б) тээвэрлэлтийн болон баглаа боодлын хэлбэр
- (в) барааг хүргэх газар
- (г) нийлүүлэгчийн гүйцэтгэх үйлчилгээ
- 17.2 Нийлүүлэгч нь захиалгын өөрчлөлтийн (цаашид өөрчлөлт гэх) улмаас гэрээнд заасан бараа нийлүүлэх хугацаа болон үнэд үзүүлэх нөлөөг (хэрэв нөлөөлөх бол) харгалzan түүний зардлын нарийвчилсан тооцоо, хэрэгжүүлэх хуваарийг өөрчилнэ. Өөрчлөлттэй холбоотой аливаа гомдол, саналыг захиалгыг өөрчлөх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор захиалагчид гаргана.
- 18. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**
- 18.1 ГЕН-ийн 17-т зааснаас бусад тохиолдолд гэрээний нөхцөл, болзлыг засварлах, эсхүл өөрчиж болохгүй. Зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.

<b>19. Гэрээний үүргийг шилжүүлэх</b>	19.1	Ямарч тохиолдолд гэрээний үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
<b>20. Гүйцэтгэлийн хугацаа сунгах</b>	20.1	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
	20.2	Гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгч болон түүний туслан гүйцэтгэгч бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлэхэд урьдчилан тооцоогүй нөхцөлийн улмаас хугацаа алдах байдал үссэн бол захиалагчид шалтгаан, үргэлжлэх хугацааг бичгээр шуурхай мэдэгдэнэ. Мэдэгдлийг авсан даруй захиалагч байдлыг үнэлж гүйцэтгэгчийн ажлын хуваарийг сунгах шийдвэрийг алданги оногдуулах эсхүл оногдуулахгүй нөхцөлтэйгээр гаргаж гэрээнд өөрчлөлт оруулна.
	20.3	ГЕН-ийн 23-т өөрөөр заагаагүй бол гүйцэтгэгчийн нийлүүлэлттэй холбоотой үүргийн биелэлтийг хангуулах үүднээс ГЕН-ийн 21-д заасны дагуу алданги оногдуулна. ГЕН-ийн 20.2-т гүйцэтгэлийн хугацааг алданги оногдуулахгүйгээр сунгахаар тохирсон бол энэ заалт хамаарахгүй.
<b>21. Алданги оногдуулах</b>	21.1	ГЕН-ийн 23 дугаар зүйлд өөрөөр заагаагүй бол, захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Дээд хэмжээнд хурсэн тохиолдолд захиалагч гэрээг ГЕН-ийн 22 дугаар зүйлийн дагуу цуцлах асуудлыг хөндөж болно.
<b>22. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах</b>	22.1	Захиалагч дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь үссэн тохиолдолд гэрээний дагуу зөрчлийг арилгах бусад эрх, үйл ажиллагаагаа үл хөндөн нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй:
	(а)	Нийлүүлэгч аль нэг болон бүх барааг гэрээнд заасан эсвэл 20 дугаар зүйлийн дагуу сунгасан хугацаанд хүргэж чадаагүй;
	(б)	Бараа нь гэрээнд заасан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангаагүй; эсхүл
	(в)	ГТН-д заасан хугацаанд тухайн барааны бүртгэлийн гэрчилгээ болон бусад баримт бичгийг ирүүлээгүй бол.
	(г)	Нийлүүлэгч тендер шалгаруулалтад оролцох, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхдээ авилгал, залилан мэхлэх үйл ажиллагаанд холбогдсон нь шүүх, эсхүл холбогдох байгууллагаар тогтоогдсон бол захиалагч түүнд гэрээ байгуулах эрх олгохгүй бөгөөд нэгэнт гэрээ байгуулах эрх олгогдсон, эсхүл гэрээ байгуулагдсан бол түүнийг цуцална.
	(д)	Нийлүүлэгч гэрээний бусад үүргээ биелүүлээгүй;
	22.2	ГЕН-ийн 22.1-ийн дагуу гэрээг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн цуцалсан тохиолдолд нийлүүлэгдээгүй барааг тохиромжтой гэж үзсэн нөхцөлөөр захиалагч худалдан авах эрхтэй ба үүнтэй холбогдон гарсан нэмэлт зардлыг нийлүүлэгч хариуцна. Энэ зүйлийг үл харгалzan нийлүүлэгч

		гэрээний цуцлагдаагүй хэсгийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
<b>23. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал</b>	23.1	ГЕН-ийн 20, 21 ба 22-т заасныг үл харгалзан, гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас хугацаа алдсан эсхүл гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх боломжгүй болсон гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа, алданги, эсхүл үүргээ биелүүлээгүйгээс гэрээ цуцлагдах хариуцлагыг хүлээхгүй.
	23.2	Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.
<b>24. Төлбөрийн чадваргүй болсны улмаас гэрээг цуцлах</b>	24.1	Нийлүүлэгч дампуурах, эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол захиалагч нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг хэдийд ч цуцлах эрхтэй. Ингэхдээ захиалагч нийлүүлэгчид учирсан хохирлыг нөхөн төлөхгүй. Гэвч ийнхүү цуцалсан нь захиалагчид үүссэн эсвэл ирээдүйд үүсэх аливаа эрх, үйл ажиллагааг хөндөхгүй.
<b>25. Захиалагчийн шаардлагаар гэрээг цуцлах</b>	25.1	Захиалагч шаардлагатай тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдэж гэрээг хэдийд ч бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцлах эрхтэй. Захиалагч мэдэгдэлдээ өөрийн шаардлагаар гэрээг цуцлах болсныг болон гэрээний аль хэсгийг, хэзээнээс цуцалж буйг заавал дурдана.
	25.2	Мэдэгдэл нийлүүлэгчид очсоноос хойш 30 хоногийн дотор тээвэрлэхэд бэлэн болсон барааг захиалагч гэрээнд заасан үнэ болон бусад нөхцөлөөр худалдаж авна. Үлдэх барааны хувьд захиалагч дор дурдсан сонголтын аль нэгийг, эсхүл хоёуланг хэрэгжүүлнэ:
	(a)	үлдэх барааны одоогоор бэлэн болсон аливаа хэсгийг гэрээнд заасан үнэ, бусад нөхцөлөөр авах, болон/эсхүл
	(б)	үлдэх барааг цуцлах ба нийлүүлэгчийн хагас бэлэн болсон бараа, гэрээг хэрэгжүүлэх зорилгоор худалдаж авсан материал, эд ангийн хэлэлцэж тохирсон үнийг төлнө. Энэ дунд захиргааны зардлын болон ашгийн зохих хэмжээг оруулж тооцно.
<b>26. Маргааныг шийдвэрлэх</b>	26.1	Захиалагч болон нийлүүлэгчийн хооронд гэрээтэй холбогдож гарч болох маргааныг зөвшилцэл болон албан бус хэлэлцээрээр шийдэхийг хичээнэ.
	26.2	Дээрх хэлэлцээр 30 хоног үргэлжлэхэд гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй бол аль ч тал гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу шүүхэд хандах эрхтэй.
<b>27. Гэрээнд ашиглах хэл</b>	27.1	Гэрээ нь ГТН-д заасан хэл дэр бичигдэнэ. ГЕН-ийн 28-д өөрөөр заагаагүй бол энэ хэл дээр бичигдсэн гэрээний хувилбарыг гэрээг тайлбарлахад мөрдөнө. Гэрээний дагуу талуудын харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.
<b>28. Гэрээнд мөрдөх хууль</b>	28.1	ГТН-д заагаагүй бол Гэрээ нь Монгол улсын хуулийг мөрдөнө.
<b>29. Мэдэгдэл</b>	29.1	Талууд гэрээтэй холбогдсон мэдэгдлийг бичгээр болон факсаар ГТН-д заагдсан хаягаар хүргүүлнэ.

- 29.2 Мэдэгдэлийг түүний хүргэгдсэн өдөр эсхүл түүнд заасан хүчинтэй хугацааны аль сүүлчийн өдрөөс хүчинтэй гэж үзнэ.
- 30. Татвар болон хураамж**
- 30.1 Монгол улсын нутаг дэвсгэрийн гаднаас нийлүүлэх бараанд Монгол улсын гадна оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 30.2 Дотоодоос нийлүүлэх бараанд захиалагчид нийлүүлэгдэх хүртлэх хугацаанд түүнд оногдуулсан бүх төрлийн татвар, хураамжийг нийлүүлэгч бүрэн хариуцна.

# НАЙМДУГААР БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), иөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-нээс \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Тендер ба үнийн хуваарь;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, есрчлелтгүйд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

## ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

*[Захиалагч байгууллагын нэр]*

*[Гүйцэтгэгчийн нэр]* нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар гэрээний дагуу *[Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт]* (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

*[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс *[баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг]*<sup>5</sup> –ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан *[баталгааны дүн тоогоор, төгрөг] [дүн үсгээр, төгрөг]*-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноог оруулах/ хугацаанд хүчинтэй.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

---

<sup>5</sup> Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

## УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТЛАН ДААЛТ)

### *[Захиалагч байгууллагын нэр]*

**[Гүйцэтгэгчийн нэр]** (цаашид “гүйцэтгэгч” гэх) ..... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... тоот **[Гэрээний нэр ба ажлын төвч тодорхойлолт]** гэрээ (цаашид “гэрээ” гэх)-ний өрөнхий нөхцөлийн 48 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэхээ баталж **[Захиалагчийн нэр]**-ийн өмнө хариуцлага хүлээж **[Баталгааны мөнгөн дүн]** **[Үсгээр]**<sup>6</sup>-ийн банкны баталгаа ирүүлэхтэй ХОЛБОГДУУЛАН,

**[Банк нэр]** (цаашид “Банк” гэх) нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, валют]** **[дүн үсгээр, валют]**<sup>7</sup>-ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг захиалагчийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсон тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж батлан даалт гаргаж байна.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, түүний дагуу гүйцэтгэх ажил, гэрээний бичиг баримтад оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэхүү баталгаа нь гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид дээр дурдсан дүнтэй ижил төлбөр эргэн төлөгдөх өдөр /огноог оруулах/ хүртэл хүчин төгөлдөр байна.

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

<sup>6</sup> Энэ дүнг банк, эсхүл санхүүгийн байгууллага бөглөх бөгөөд урьдчилгаа төлбөрийн үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь урьдчилгаа төлбөрийн валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

<sup>7</sup> Энэ дүнг баталгаа гаргагч бөглөх бөгөөд гэрээнд заасан гэрээний үнийн хувийг илэрхийлнэ. Энэ нь гэрээний валютаар, эсхүл захиалагчийн хүлээн зөвшөөрсөн чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлэгдэнэ.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>8</sup> : 2019,01,15

Тендер шалгаруулалтын нэр: Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах  
Тендер шалгаруулалтын дугаар: ЭСҮТ/201901007

**Эмгэг Судлалын Үндэсний Төв** эрх бүхий тендерт оролцогчдоос 2019 оны эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг хүсэлтээ гаргаж эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000** төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.  
Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жилийн аль нэг жилийн борлуулалтын хэмжээ нь санал болгож буй нийт үнийн дунгийн 50 % -иас багагүй байна**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй багцын нийт үнийн дунгийн 50%-тай тэнцэх**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2017 он**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис хангах нийлүүлэх**

Тендерийн хамт тендерийн баталгаа ирүүлнэ.

*Багц1-252000*

*Багц2-417900*

*Багц3-435380*

*Багц4-764140*

*Багц5-184855*

Тендерийг **2019 оны 02 дугаар сарын 15-ны 09:00 цаг**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн, **09:30 цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Эмгэг Судлалын Үндэсний Төв**  
**2 давхар 14 тоот, У.Отгончимэг, утас:313820**